



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/313

Ховд


Г Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А" заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүүлийн жилүүдэд олон улсын худалдааны хорио цээрт мал амьтны гоц халдварт өвчин зүүн, төв, хангайн бүсийн зарим аймгуудад гарч, малын гоц халдварт өвчний халвар тархах эрсдэл өндөр байгаа тул гоц халдварт өвчний эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 оны 5 дугаар сарын 20 –аас эхлэн нэг жилийн хугацаанд тус аймгийн нутаг дэвсгэрт зүүн болон төвийн бүсийн аймгуудаас мал амьтан оруулах, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, шилжилт хөдөлгөөний хяналтыг өндөржүүлэн захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт сум багийн Засаг дарга, сумын хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасгийн дарга наарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж заавраар ханган илэрсэн зөрчлийг шуурхай шийдвэрлэж, тайланг улирал бүр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/ -т даалгасугай.



Б. ДҮГЭРЖАВ

02 01535

Zax A/313 Ch